

**ЗАВХАН АЙМГИЙН
“АЛТАН ГАДАС” ОДОНТ НЭГДСЭН
ЭМНЭЛЭГ**

81090 Улиастай, Завхан аймаг

Утас/Факс: 7046-26-14

И-мэйл: emnelegzavkhan@gmail.com

ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД

2024.02.02 № 01/66
танай _____-ны № _____ т

Тодруулга хүргүүлэв

Завхан аймгийн нэгдсэн эмнэлгийн зарласан “Завхан аймгийн нэгдсэн эмнэлгийн 2024 онд хэрэглэгдэх эм, эмнэлгийн хэрэгслийг ханган нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ЗНЭ/20240102002 тоот тендерт оролцохоор сонирхож буй Саммитмедикал Сервис ХХК –аас ирүүлсэн тодруулга бичгийн хариуг хүргүүлж байна. Мөн тендерийн баталгаа ирүүлэх тухай мэдэгдэж байна.

1. Саммитмедикал Сервис ХХК нь тодруулга хүссэн бичигт Багц №19 –ийн №1-д заасан Ариутгалын бодис / ус төрөгчийн хэт исэл/ нь Химийн хорт болон аюултай бодис импортлох, экспортлох, хил дамжуулан тээвэрлэх, ашиглах, худалдах, үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийн дагуу нийлүүлэгддэг бодисыг тус багцын 2 болон 3-т заасан Эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх тусгай зөвшөөрлийн дагуу нийлүүлэгддэг рентген хальстай 1 багц болгон зарласан нь зөвхөн эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх тусгай зөвшөөрөлтэй оролцогч нарын өрсөлдөөнийг хязгаарлаж байгаа нь “Төрийн болон орон нутгийн өмчийн бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 10.5 Захиалагч өрсөлдөөнийг дэмжих зорилгоор бараа, ажил, үйлчилгээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар багцалж болно. Гэсэн заалттай зөрчилдөж байна. Иймд тус бүрийн хамрах тусгай зөвшөөрлийн чиг үүргийн дагуу тус тусад нь багцалж тэгш өрсөлдөх боломжийг хангаж өгнө үү гэсний дагуу багц №19-ийг хоёр салгаж “ Багц №19-1 Ариутгалын бодис, Багц №19-2 Рентген” тус тусад багцалж байна.
2. “Төрийн болон орон нутгийн өмчийн бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14.1.2-ыг үндэслэн 100сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй багцуудын тендерийн баталгааг ирүүлэхгүй байхыг үүгээр мэдэгдэж байна.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ БОЛОРМАА



9039125 СТА0430